

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд хэмжил зүйн бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, хэмжил зүйн чиглэлээр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хэмжил зүйн тухай хууль тогтоомж

2.1.Хэмжил зүйн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хэмжил зүй” гэж хэмжлийн тухай шинжлэх ухаан, түүний хэрэглээг;

3.1.2.“хэмжил” гэж хэмжигдэхүүний тоон утгыг тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.3.“хэмжлийн нэгж” гэж хэмжил гүйцэтгэхэд жишиг болгон сонгож авсан нэгж хэмжигдэхүүнийг;

3.1.4.“хэмжлийн эталон” гэж хэмжлийн нэгж, түүний тодорхой утгыг тогтоох, бий болгох, хадгалах, хуулбарлах, харьцуулах замаар бусад хэмжих хэрэгсэлд дамжуулах зориулалттай хэмжих хэрэгслийг;

3.1.5.“улсын эталон” гэж хэмжлийн нэгжийн эталоны утгыг тогтоох, дамжуулах зорилгоор үндэсний хэмжээнд хэрэглэхээр Засгийн газраас баталсан хэмжлийн эталоныг;

3.1.6.“анхдагч эталон” гэж хамгийн өндөр нарийвчлалтайгаар хэмжлийн нэгжийг бий болгох, түүний эталоны утгыг хадгалах, дамжуулах зориулалттай хэмжлийн эталоныг;

3.1.7.“хэмжих хэрэгсэл” гэж хэмжил гүйцэтгэхэд ашиглаж байгаа хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгслийг;

3.1.8.“нэгж дамжуулалт” гэж хэмжлийн нэгжийн эталоны утгатай шалгалт тохируулгын зохих шатлалаар харьцуулсан хэмжлийн үр дүнгийн шинж чанарыг тогтоох үйл ажиллагааг;

3.1.9.“хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга” гэж хэмжлийн тодорхой нөхцөлд шалгагдаж байгаа хэмжих хэрэгслийн заалтыг тухайн эталоны утгатай харьцуулж, хэмжлийн үр дүнг тогтоох үйл ажиллагааг;

3.1.10.“стандартчилсан загвар” гэж бодис, материалын нэгэн төрлийн ба тогтвортой байдлыг тодорхойлохоор зохион бүтээгдсэн, хэмжил гүйцэтгэхэд ашиглах эсвэл хэвийн шинж чанарыг тогтоох зориулалттай жишиг материалыг;

3.1.11.“хэмжил зүйн хяналт шалгалт” гэж хэмжил зүйн салбарт төрөөс хууль эрх зүй, зохицуулалтыг хэрэгжүүлэх дадал, үйл ажиллагааг;

3.1.12.“хэмжил гүйцэтгэх аргачлал” гэж хэмжил гүйцэтгэх үндэслэл болгосон физикийн зарчим, тухайн хэмжих хэрэгслийг ашиглах нөхцөл, аргазүйг тогтоосон журмыг;

3.1.13.“хэмжил зүйн мэргэжлийн байгууллага” гэж тухайн салбартаа хэмжил зүйн тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн болон төрийн өмчит байгууллагыг;

3.1.14.“хэмжих хэрэгслийн загварын туршилт” гэж эрх бүхий байгууллагаас хэмжих хэрэгслийн тодорхой загварт хийсэн туршилтын үр дүнг гэрчилгээгээр илэрхийлэх тохирлын үнэлгээний үйл ажиллагааг;

3.1.15.“хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт” гэж хэмжих хэрэгсэл нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг эрх бүхий байгууллагаас шалган нотолж, баталгаажуулалтын лац, эсхүл тэмдгээр битүүмжлэн гэрчилгээ олгох тохирлын үнэлгээний үйл ажиллагааг;

3.1.16.“савласан бүтээгдэхүүн” гэж бүтээгдэхүүний тоон хэмжээг урьдчилан тогтоож, өөрчлөх боломжгүйгээр битүүмжилсэн бараа материалыг.

3.2.Энэ хуулийн 3.1-д зааснаас бусад нэр томъёог Хэмжил зүйн олон улсын байгууллага болон Стандартчиллын олон улсын байгууллагаас стандарт дагуу баталсан нэр томъёоны тодорхойлолт, тайлбар толь бичигт зааснаар ойлгож хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЭМЖИЛ ЗҮЙН НЭГДСЭН БОДЛОГО, БҮРЭЛДЭХҮҮН

4 дүгээр зүйл.Хэмжил зүйн бодлого, бүрэлдэхүүн

4.1.Хэмжил зүйн нэгдсэн бодлого нь улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, худалдаан дахь техникийн саад, тотгорыг багасгахад чиглэсэн хэмжил зүйн тогтолцоог хангахад оршино.

4.2.Хэмжил зүйн нэгдсэн бодлого нь доор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

4.2.1.хууль эрх зүйн бүрэлдэхүүнд хэмжил зүйн бодлого, хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, дүрэм, журам;

4.2.2.хэмжил зүйн зохион байгуулалтын бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүн, Хэмжил зүйн Зөвлөл, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллага;

4.2.3.шинжлэх ухааны бүрэлдэхүүнд хэмжил зүйн судалгаа, шинжилгээ, боловсрол, мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтын тогтолцоо, олон улс, бүс нутгийн гадаад хамтын ажиллагаа;

4.2.4.техникийн бүрэлдэхүүнд хэмжлийн нэгж, эталон, стандартчилсан загвар, нэгж дамжуулалт, шалгалт тохируулга, ажлын хэмжих хэрэгсэл, хэмжил зүйн хяналт шалгалт.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЭМЖЛИЙН НЭГЖ, ЭТАЛОН, НЭГЖ ДАМЖУУЛАЛТ

5 дугаар зүйл.Хэмжлийн нэгж

5.1.Монгол Улсад хэрэглэх хэмжлийн нэгж нь Олон улсын жин хэмжүүрийн байгууллагын Ерөнхий бага хурлаас тогтоосон Хэмжлийн нэгжийн олон улсын систем (SI)-ийн нэгж байна.

5.2.Энэ хуулийн 5.1-д зааснаас бусад хэмжлийн нэгжийг Засгийн газраас тогтоосноор Хэмжлийн нэгжийн олон улсын системийн нэгжтэй нэгэн адил хэрэглэж болно.

5.3.Хэмжлийн нэгжийн нэр, тэмдэглэгээ болон тэдгээрийг бичих, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

5.4.Экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний чанар, техникийн үзүүлэлтийг захиалагчийн хүсэлтээр энэ хуулийн 5.1-д зааснаас хэмжлийн өөр нэгжээр илэрхийлж болно.

6 дугаар зүйл.Хэмжлийн нэгжийн эталон, стандартчилсан загвар

6.1.Хэмжлийн нэгжийн улсын эталоныг Засгийн газар, стандартчилсан загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус батална.

6.2.Улсын болон анхдагч эталон нь төрийн хамгаалалтад байна.

6.3.Стандартчилсан загварыг бодис болон материалын бүтэц, шинж чанарын нэгжээр илэрхийлсэн үзүүлэлтийг гаргах, хадгалах, дамжуулахад хэрэглэнэ.

6.4.Улсын болон анхдагч эталон, батлагдсан стандартчилсан загварыг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.

7 дугаар зүйл.Нэгж дамжуулалт

7.1.Улсын болон анхдагч эталон, стандартчилсан загварын нэгж нь энэ хуулийн 5.1-д заасан хэмжлийн нэгжтэй уялдаж нийцсэн байна.

7.2.Улсын ба анхдагч эталон, стандартчилсан загварын нэгж дамжуулалтыг олон улсын болон гадаад орны хүлээн зөвшөөрөгдсөн эталонтой харьцуулах замаар хангана.

7.3.Хэмжлийн нэгжийг баталсан аргачлалын дагуу холбогдох эталон, хэмжих хэрэгсэлд дамжуулна.

7.4.Ажлын эталонд нэгж дамжуулалтыг улсын болон анхдагч эталонгоос, эсхүл гадаад орны хүлээн зөвшөөрсөн дээд шатны эталонгоос гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл.Хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлал

8.1.Хэмжлийг стандарт, арга, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

8.2.Хэмжил гүйцэтгэх байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил гүйцэтгэх арга, аргачлалыг боловсруулж, батална.

8.3.Хэмжих хэрэгсэл нь стандартын, хэмжил зүйн, техникийн болон ашиглалтын шаардлагыг хангасан байна.

8.4.Энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд загвар нь батлагдсан, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн, баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийг ашиглан хэмжил гүйцэтгэнэ.

8.5.Энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл нь хэмжлийн үр дүнд нөлөөлөхөөс сэргийлсэн хийц, битүүмжлэлтэй байна.

8.6.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэлд тавих тусгай шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно.

8.7.Энэ хуулийн 8.6-д заасан техникийн зохицуулалтыг Засгийн газар

батална.

9 дүгээр зүйл.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга

9.1.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулж болно.

9.2.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад чадавхиа үнэлүүлсэн шалгалт тохируулгын ажилтан хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг нэгж дамжуулалт бүхий эталон ашиглан батлагдсан стандарт, арга, аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

9.3.Шалгалт тохируулгын лаборатори нь хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга гүйцэтгэх арга, аргачлалтай байна.

9.4.Шалгалт тохируулга хийсэн тухайн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулгын лаборатори нь гэрчилгээ олгож, тэмдэг дарна.

9.5.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын лаборатори нь итгэмжлэгдэж болно.

9.6.Хэмжил зүйн олон улсын байгууллагатай харилцан хүлээн зөвшөөрөх гэрээнд нэгдэн орсон гадаад орны хэмжил зүйн байгууллагын шалгалт тохируулгын гэрчилгээ, үр дүнг хүлээн зөвшөөрнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

10 дугаар зүйл.Хэмжил зүйн хяналт шалгалт, хамрах хүрээ, хэлбэр

10.1.Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн хяналт шалгалтад заавал хамруулна:

10.1.1.хүн, мал эмнэлгийн оношлогоо, эмчилгээ;

10.1.2.үндэсний аюулгүй байдлыг хангах;

10.1.3.байгаль орчны хамгаалах;

10.1.4.улсыг батлан хамгаалах;

10.1.5.худалдаа, үйлчилгээний тооцоо.

10.2.Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагаа нь дараахь хэлбэртэй байна:

10.2.1.хэмжих хэрэгслийн загварыг турших;

10.2.2.хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах;

10.2.3.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортоор нийлүүлэх,

суурилуулах, засварлах аж ахуйн нэгжийн чадавхийг үнэлэх, бүртгэх.

10.3.Хэмжил зүйн төрийн хяналт нь дараахь төрлөөс бүрдэнэ:

10.3.1.хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

10.3.2.савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт шалгалт хийх.

11 дүгээр зүйл.Хэмжих хэрэгслийн загварын туршилт

11.1.Энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулна.

11.2.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

11.3.Энэ хуулийн 10.1.1-10.1.4-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад чадавхиа үнэлүүлж нотлуулсан, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан хэмжил зүйн мэргэжлийн байгууллага холбогдох салбарын хүрээнд гүйцэтгэж болно.

11.4.Загварын туршилтад тэнцсэн, эсхүл загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэмжих хэрэгслийг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэж, загварыг баталсан гэрчилгээ олгоно.

11.5.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг холбогдох стандарт болон энэ хуулийн 11.6-д заасан журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

11.6.Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журмыг энэ хуулийн 18 дүгээр зүйлд заасан Хэмжил зүйн зөвлөл батална.

11.7.Импортоор нийлүүлэх хэмжих хэрэгсэлд дараахь байгууллагаас загварыг нь баталж, гэрчилгээ олгосон тохиолдолд загварын туршилтыг давтан хийхгүйгээр хүлээн зөвшөөрнө:

11.7.1.Хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага /OIML/;

11.7.2.энэ хуулийн 11.7.1-д заасан байгууллагаас эрх авсан хэмжил зүйн байгууллага, үйлдвэрлэгч;

11.7.3.энэ хуулийн 19.1-д заасан байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулсан гадаад орны хэмжил зүйн төв байгууллага.

12 дугаар зүйл.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт

12.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлсэн, үйлдвэрлэл, суурилуулалт, засвараас гарсны дараа болон тэдгээрийг ашиглахын өмнө баталгаажуулалтад заавал хамруулна.

12.2.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага эрхэлнэ.

12.3.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад чадавхиа үнэлүүлж, нотлуулсан, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь энэ хуулийн 10.1.1-10.1.4-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг холбогдох салбарын хүрээнд гүйцэтгэж болно.

12.4.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас улсын шалгагчийн эрх авсан ажилтан холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

12.5.Баталгаажуулалтад тэнцсэн хэмжих хэрэгслийг баталгаажуулалт хийсэн байгууллага лац, тэмдгээр битүүмжилж, гэрчилгээ олгоно.

12.6.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лац, тэмдэг, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

12.7.Баталгаажуулалтын лац, тэмдэг нь хөндөгдсөн буюу арилсан, гэрчилгээг үрэгдүүлсэн, хуурамчаар үйлдсэн, баталгаажуулалтын хугацаа дууссан, эвдэрсэн буюу буруу заалттай хэмжих хэрэгслийг баталгаагүйд тооцно.

12.8.Энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд баталгаагүй хэмжих хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглоно.

12.9.Загварын туршилтад хамрагдаж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулахгүй.

12.10.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацааг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

12.11.Энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил, хэмжих хэрэгслийн жагсаалтыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.12.Хэмжил зүйн олон улсын байгууллага болон үйлдвэрлэгч орны хэмжил зүйн байгууллагаас хэмжих хэрэгслийн анхдагч баталгаажуулалт хийх эрх авсан, олон улсын итгэмжлэлийн тогтолцооны дагуу итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчийн хэмжих хэрэгслийн анхдагч баталгаажуулалтын үр дүнг тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрч болно.

12.13.Хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийх журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

13 дугаар зүйл.Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, импортын нийлүүлэлт, суурилуулалт, засвар эрхлэх аж ахуйн нэгжийн чадавхийг үнэлэх, бүртгэх

13.1.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх,

суурилуулах, засварлах, импортоор нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхийг үнэлж, нотлогдсон тохиолдолд хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.

13.2.Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлагыг стандартаар тогтооно.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхийг үнэлэх, нотлох, мэдээллийн санд бүртгэх журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

14 дүгээр зүйл.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хэмжил зүйн хяналт, шалгалт

14.1.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга нь холбогдох дүрэм, журам, стандартад заасан хэмжил зүйн шаардлагыг хангасан байна.

14.2.Савласан бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго нь стандартын шаардлага хангасан байна.

14.3.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

15 дугаар зүйл.Хэмжил зүйн төрийн хяналт

15.1.Хэмжил зүйн төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараахь хяналтыг хэрэгжүүлнэ:

15.2.1.хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

15.2.2.баталгаагүй, эсхүл загвар нь батлагдаагүй буюу баталсан загвартаа тохирохгүй байгаа, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй хэмжих хэрэгслийн ашиглалт, суурилуулалтыг хориглох, тэдгээрийг улсын хилээр нэвтрүүлэхгүй байхад хяналт тавих;

15.2.3.хэмжлийн нэгж нь зөвшөөрөгдсөн нэгжтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих;

15.2.4.хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах үйл ажиллагаанд хяналт тавих;

15.2.5.хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, ашиглалт, хэвийн ажиллагаанд хяналт тавих;

15.2.6.савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт тавих;

15.2.7.хэмжил зүйн хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх.

15.3.Энэ хуулийн 15.2.1-15.2.7-д заасан хэмжил зүйн хяналтыг хэрэгжүүлэх улсын байцаагч нь хэмжил зүйн чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

15.4.Хэмжил зүйн төрийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь хэмжил зүйн хяналтын үр дүнг энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан Зөвлөлд жил бүр тайлагнана.

ТАВДУГААР БҮЛЭГ ХЭМЖИЛ ЗҮЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮРЭН ЭРХ

16 дугаар зүйл.Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо

16.1.Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо нь Хэмжил зүйн зөвлөл, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаас бүрдэнэ.

17 дугаар зүйл.Засгийн газрын гишүүний бүрэн эрх

17.1.Засгийн газрын гишүүн нь хэмжил зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.эрхэлсэн асуудлын хүрээний хэмжил зүйн бодлогыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах;

17.1.2.эрхэлсэн асуудлын хүрээний хэмжлийн нэгжийн улсын болон анхдагч эталоныг бий болгох, хөгжүүлэх;

17.1.3.эрхэлсэн асуудлын хүрээний хэмжил зүйн стандарт, дүрэм, журам, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

18 дугаар зүйл.Хэмжил зүйн зөвлөл

18.1.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хэмжил зүйг хөгжүүлэх, хэмжил зүйн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий орон тооны бус Хэмжил зүйн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг төр, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулан ажиллуулна.

18.2.Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

18.3.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга Зөвлөлийн хуралдааныг даргална.

18.4.Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.4.1.Хэмжил зүйн нэгдсэн бодлогын асуудал, хууль тогтоомжийн биелэлтийн явцыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

18.4.2.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаар болон шийдвэрийн биелэлтийн талаарх судалгаа, мэдээг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулах;

18.4.3.хэмжил зүйн нэгдсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар чиглэл, зөвлөмж, үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих;

18.4.4.хэмжил зүйн чиглэлээр болон төрийн хяналт шалгалтын дүгнэлтийн талаарх мэдээ, тайланг холбогдох байгууллагаас гаргуулах, хэлэлцэх;

18.4.5.Зөвлөлийн шийдвэрийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавих;

19 дүгээр зүйл.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

19.1.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

19.2.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.2.1.хэмжил зүйн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

19.2.2.хэмжил зүйн дүрэм, журам баталж, хэрэгжилтийг хангах;

19.2.3.эталоныг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх;

19.2.4.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхийг энэ хуулийн 13.3-т заасан журмын дагуу үнэлж нотлох;

19.2.5.энэ хуулийн 21.1-д заасан хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхийг үнэлэх журмыг батлах, хэрэгжилтийг хангах;

19.2.6.хариуцсан асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бүс нутаг, гадаад улс орны хэмжил зүйн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэмжлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх ажлыг зохион байгуулах;

19.2.7.хэмжил зүйн асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах;

19.2.8.улсын шалгагчийн эрх олгох, аттестатчилах;

19.2.9.хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг хөтлөх.

19.3.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улсын эталоныг бий болгох, хөгжүүлэх, нэгж дамжуулалтыг хангах чиг үүрэг бүхий Хэмжил зүйн хүрээлэнтэй байна.

19.4.Хэмжил зүйн хүрээлэн дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.4.1.хэмжлийн нэгжийн улсын болон анхдагч эталон, стандартчилсан загварыг бий болгох, зохион бүтээх, хадгалах, харьцуулан дүйлгэж баталгаажуулах;

19.4.2.хэмжил зүйн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил, туршилт хийх;

19.4.3.улсын болон анхдагч эталоны нэгж дамжуулалтыг олон улсад болон үндэсний хэмжээнд хангах;

19.4.4.өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх;

19.4.5.үндэсний болон олон улсын хэмжлийн харьцуулалтад оролцох, зохион байгуулах;

19.4.6.хэмжил, шалгалт тохируулгын чадавхийг Жин, хэмжүүрийн олон улсын байгууллагын мэдээллийн санд бүртгүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх;

19.4.7.хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх.

19.5.Хэмжлийн нэгжийн улсын болон анхдагч эталоны хөтлөлт, нэгж дамжуулалтын журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

20 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага

20.1.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага харьяалах нутаг дэвсгэртээ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1.хэмжил зүйн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

20.1.2.анхдагч болон ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах;

20.1.3.хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийх;

20.1.4.хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэх.

20.2.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

21 дүгээр зүйл.Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага

21.1.Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага энэ хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлж болно:

21.1.1.Энэ хуулийн 10.1.1-10.1.4-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх, холбогдох салбарын хүрээний хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх;

21.1.2.тухайн хэмжлийн төрлөөр улсын, анхдагч болон ажлын эталоныг бий болгох, стандартчилсан загвар зохион бүтээх, хадгалах, нэгж дамжуулалтыг хангах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

22 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллага

22.1.Аж ахуйн нэгж, байгууллага, түүний удирдлага нь эрхэлсэн ажил, үйлчилгээнийхээ хүрээнд хэмжил зүйн чиглэлээр дараахь эрх, үүрэгтэй:

22.1.1.хэмжил зүйн ажлыг тодорхой нэгж, албан тушаалтанд хариуцуулах, шаардлагатай тохиолдолд хэмжил зүйн албыг байгуулан ажиллуулах;

22.1.2.хэмжлийн шаардагдах нарийвчлал, хязгаарт тохирсон хэмжих хэрэгслийг ашиглах;

22.1.3.байгалийн нөөцийн олборлолт, ашиглалт, худалдаа, үйлчилгээний тооцоог зөвхөн баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслээр гүйцэтгэх;

22.1.4.энэ хуулийн 10.1-д зааснаас бусад үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх;

22.1.5.гүйцэтгэсэн хэмжлийн үр дүнгийн найдвартай, үнэн зөв байдлыг хариуцах;

22.1.6.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас чадавхиа үнэлүүлж нотлуулах, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлэх;

22.1.7.энэ хуулийн 14.1, 14.2-т заасан шаардлагыг хангасан савласан бүтээгдэхүүний тоон хэмжээ, зөвшөөрөх хэлбэлзлийн утгыг сав, баглаа боодлын шошгонд үндэсний стандартын дагуу тэмдэглэх;

22.1.8.хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт болон бусад ажил, үйлчилгээний зардлыг бүрэн хариуцах.

22.2.Аж ахуйн нэгж, байгууллага, түүний хэмжил зүйн алба нь хэмжил зүйн дотоод хяналтыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

22.2.1.хэмжих хэрэгслийг загварын туршилт, шалгалт баталгаажуулалтад хугацаанд нь бүрэн хамруулж байгаа эсэхэд хяналт тавих;

22.2.2.өөрийн хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулах;

22.2.3.хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, ашиглалтад болон хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжлийн шаардагдах нарийвчлал, хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах.

23 дугаар зүйл.Иргэн, төрийн бус байгууллага

23.1.Иргэн, төрийн бус байгууллага хэмжил зүйн үйл ажиллагааны чиглэлээр дараахь эрх, үүрэгтэй:

23.1.1.хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт, хэмжил зүйн төрийн хяналт хийлгэх хүсэлт гаргах;

23.1.2.хэмжил зүйн ажил, үйлчилгээ, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын талаар мэдээлэл авах;

23.1.3.хэмжих хэрэгслийн ашиглалт, хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын явцад гарсан зөрчлийг эрх бүхий байгууллагад мэдээлэх, гарсан зөрчлийг арилгах талаар шаардах, шийдвэрлүүлэх;

23.1.4.хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох, энэ талаар санал, хүсэлт гаргах.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл.Хэмжил зүйн үйл ажиллагааны санхүүжилт

24.1.Хэмжил зүйн зөвлөл, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

24.2.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг хэмжил зүйн салбарыг бэхжүүлэх арга хэмжээнд зарцуулна.

24.3.Хэмжил зүйн олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

24.4.Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Хэмжил зүйн тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд, иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2018 оны ...дугаар
сарын-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр баталсан Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2018 оны ...дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2018 оны ...дугаар
сарын-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 15 дугаар зүйлийн 15.17 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2018 оны ...дугаар
сарын-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” гэснийг “Хэмжил зүйн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.24 дүгээр зүйл дэх “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль зөрчих” гэснийг “Хэмжил зүйн тухай хууль зөрчих” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 10.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажуулалтад хамрагдаагүй, эсхүл ашиглалт, суурилуулалтын шаардлага хангаагүй хэмжих хэрэгслийг ашигласан” гэснийг “Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажуулалтад хамрагдаагүй, эсхүл ашиглалт, суурилуулалтын шаардлага хангаагүй хэмжих хэрэгслийг хүн, мал эмнэлгийн оношлогоо, эмчилгээ, аюулгүй байдлыг хангах, байгаль орчны хамгаалал, улсыг батлан хамгаалах, худалдаа, үйлчилгээний тооцооны үйл ажиллагаанд ашигласан бол” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 10.24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл улсын бүртгэлд бүртгэгдээгүй, баталгаажуулалтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг үйлдвэрлэсэн, худалдсан, эсхүл суурилуулсан, эсхүл засварласан” гэснийг “хүн, мал эмнэлгийн оношлогоо, эмчилгээ, аюулгүй байдлыг хангах, байгаль орчны хамгаалал, улсыг батлан хамгаалах, худалдаа, үйлчилгээний тооцооны үйл ажиллагаанд ашиглах хэмжих хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэхгүйгээр импортоор нийлүүлсэн, үйлдвэрлэсэн, засварласан, эсхүл суурилуулсан, эсхүл баталгаажуулалтад хамруулахгүйгээр хэмжих хэрэгслийг худалдсан бол” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг